



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, 9.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 13 дугаар тогтоол, тус яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Зөвлөлийн дарга

Төрийн нарийн бичгийн дарга

Зөвлөлийн гишүүд

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Кибер аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Хуулийн хэлтсийн дарга

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга

Сансрын холбооны хэлтсийн дарга

995571

Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга

Цахим засаглалын хэлтсийн дарга

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах зохион байгуулагч

2.Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх “Удирдлагын зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар шийдвэр гаргахад идэвхтэй оролцож, түүний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлагын зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ч.ЗОЛБАЯР

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн
А/98 дугаартай тушаалын хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ДЭРГЭДЭХ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх удирдлагын зөвлөл /цаашид “Удирдлагын зөвлөл” гэх/-ийн хурлыг тус яамны үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын шуурхай байдлыг хангах, яамны эрхлэх үйл ажиллагааны хүрээнд тулгамдсан зорилтыг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргахад зөвлөх зорилгоор зохион байгуулна.

1.2.Энэ журмаар Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой хурлын дэгийг тогтооно.

1.3.Удирдлагын зөвлөлийн үйл ажиллагаа нь хууль дээдлэх, хамтын удирдлагын ил тод байдал, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

**Хоёр. Удирдлагын зөвлөлийн
үйл ажиллагааны зохион байгуулалт**

2.1.Удирдлагын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Хурлын шийдвэр нь тэмдэглэл байна.

2.2.Хурлыг Төрийн нарийн бичгийн дарга даргална.

2.3.Хурлын зохион байгуулалт, бэлтгэлийг хангах асуудлыг Төрийн захиргааны удирдлагын газраас эрхлэн гүйцэтгэнэ.

2.4.Хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний төслийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга урьдчилан танилцаж хянасны үндсэн дээр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна.

2.5.Хурлыг 7 хоног бүрийн Даваа гарагт зарлан хуралдуулах бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын саналаар хугацааг тухай бүр товлон. Ажлын зайлшгүй шаардлагаар товлосон хугацаанд хурлыг хийж чадахгүйд хүрвэл хугацааг өөрчилж, дахин товлон.

2.6.Хурлыг гишүүдийн 70-аас дээш хувь нь ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.7.Удирдлагын зөвлөлийн гишүүн нь албан ажлын болон хувийн шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлын нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэж, хурал даргалагчаас чөлөө авсан байна.

2.8.Хурлын хэлэлцэх асуудлын шаардлагыг харгалзан Удирдлагын зөвлөлийн гишүүдээс гадна салбарын болон харьяа байгууллагын төлөөлөл, зөвлөх, мэргэжилтнийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.